

НҮБ-ын Хүний Эрхийг Хамгаалагчдын Тунхаглал

Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал

1998 оны 12-р сарын 9-ний өдрийн Ерөнхий Ассемблейн Тогтоол 53/144

Монгол хэлээр/ Mongolian

Translated by

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Printed by

FORUM-ASIA

**Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний
эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах,
хөхиүлэн дэмжих талаар хувь хүн
болон нийгмийн бүлэг, байгууллагын
эрх үүргийн тухай тунхаглал**

**НҮБ-ын Хүний Эрхийг Хамгаалагчдын
Тунхаглал**

Монгол хэлээр / Mongolian

Copyright © 2013

Cover/ Layout:
Prachoomthong

Translated by
Amnesty International Mongolia
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу-44
Утас/факс: (0) 976 (11) 324705
Цахим шуудан: aimncc@magicnet.mn
Шуудан хаяг: Монгол улс,
Улаанбаатар – 210648, ш/х-180

www.amnesty.mn

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Printed by:
Asian Forum for Human Rights and Development
(FORUM-ASIA)
66/2 Pan Road, Silom, BangRak, Bangkok, 10500 Thailand
Tel: +66 2 6379126
Fax: +66 2 6379128
Email: info@forum-asia.org

www.forum-asia.org

FORUM-ASIA

This book was written for the benefit of human rights defenders and may be quoted from or copied so long as the source and authors are acknowledged.

Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал

Ерөнхий Ассамблей,

Дэлхийн бүх орны хүн бүрт хүний бүхий л эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн НҮБ-ын Дүрмийн бүхий л зарчмуудыг дагаж мөрдөхийн чухлыг дахин баталж,

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын болон хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн олон улсын хичээл зүтгэлийн үндсэн элементүүд болж нэгтгэгдсэн Хүний Эрхийн 2200 А (XXI) Тогтоолоорх Олон улсын гэрээний баримт бичгүүдийн ач холбогдлыг дахин баталж, мөн НҮБ-ын тогтолцооны хүрээнд болон мөн түүнчлэн бүс нутгийн түвшинд батлагдсан бусад хүний эрхийн баримт бичгүүдийн ач холбогдлыг дахин баталж,

Арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрөлтийн болон бусад статус зэрэг аливаа төрлийн ялгаваргүйгээр бүх нийтийн хүний эрх, эрх чөлөөг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжиж, зоригжуулах чухал үүрэг хариуцлагаа олон улсын нийгэмлэгийн бүх гишүүн орон хамтран болон тусдаа ханган биелүүлэх ёстой гэдгийг онцлон тэмдэглэж,

Дүрмээр хүлээсэн энэ үүргээ биелүүлэхийн тулд олон улсын хамтран ажиллахын онцгой ач холбогдлыг дахин баталж,

Хувь хүний болон хэсэг бүлэг хүмүүсийн хүний эрх, эрх чөлөөг зөрчих болон апартейд, арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэр, колоничлол, гадаадынхны эрх мэдэл болон эзлэн түрэмгийлэл, үндэсний тусгаар тогтнол руу дайрч довтлох, аюул занал учруулах, үндэсний эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал зэргээс улбаалан үүсч байгаа өргөн олныг хамарсан хүний эрхийн жигшин зэвүүцмээр байнгын бүхий л

зөрчлүүдийг үр нөлөөтэй арилгах болон улс түмний өөртөө засан тогтнох эрх болон хүн бүрийн бүрэн тусгаар тогтносон орныхоо баялаг, байгалийн баялагийг ашиглах эрхтэйг татгалзахаас хүлээн зөвшөөрүүлэхэд олон улсын хамтын ажиллагааны гүйцэтгэх эрхэм үүргийн болон бие хүн, бүлэг болон эвсэл холбоодын явуулж байгаа үйл ажиллагааны зүгээс оруулах хувь нэмрийн ач тусыг санаж,

Олон улсын энх тайван ба аюулгүй байдал болон хүний эрх, эрх чөлөөгөө сэтгэл ханамжтай эдлэх хоёрын хоорондох харилцааг хүлээн зөвшөөрөн, олон улсын энх тайван ба аюулгүй байдал тогтоогүй байх нь зөвшилцөөнд хүрээгүйг зөвтгөхгүйг анхааран үзэж,

Хүний бүхий л эрх, эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай бөгөөд эдгээр эрх, эрх чөлөө бүрийг хөхиүлэн дэмжиж, хэрэгжүүлэхдээ шударга, өв тэгш байдлаар, ямарч хор хөнөөлгүйгээр хэрэгжүүлэх ёстойг дахин баталж,

Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хамгаалах нь Гишүүн орон бүрийн эн тэргүүний үүрэг хариуцлага мөн гэдгийг онцлон тэмдэглэж,

Бие хүн, бүлэг ба эвсэл холбоод нь үндэсний ба олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөний тухай мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих эрх ба үүрэгтэйг хүлээн зөвшөөрч,

Тунхаглаж байна:

1 дүгээр зүйл

Хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй.

2 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр, хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд бүх эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэхэд шаардагдах нийгэм, эдийн засаг, улс төрийн болон мөн хууль эрх зүйн баталгааг бүрдүүлж өгөхөд шаардагдах бүхий л нөхцөл байдлуудыг бий болгоход шаардлагатай алхмуудыг батлах замаар хүний бүхий л эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих болон хэрэгжүүлэх эн тэргүүний үүргийг хүлээнэ.

2. Оролцогч улс бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг үр дүнтэйгээр баталгаажуулсан байхад шаардлагатай хууль тогтоомж, захиргааны болон бусад алхамуудыг батлах ёстой.

3 дугаар зүйл

НҮБ-ын Дүрмэнд нийцсэн дотоодын хууль, тогтоомж болон хүний эрх, эрх чөлөөний талбарт Гишүүн орны хүлээх бусад олон улсын үүрэг хариуцлага нь хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх хуулийн хүрээ болох бөгөөд хүний тэдгээр эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах болон хүндэтгэн биелүүлэхийн тулд энэхүү Тунхаглалд заасан бүхий л үйл ажиллагааг авч явуулах ёстой.

4 дүгээр зүйл

Энэхүү Тунхаглалд заасан аливаа зүйл, заалтыг НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчмуудыг бууруулах, эсвэл үгүйсгэн няцаах байдлаар эсвэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүний эрхийн олон улсын Гэрээнүүдийн зүйл заалтуудыг болон бусад энэ талбар дахь олон улсын баримт бичиг болон харилцан зөвшилцсөн үүргийг хязгаарласан буюу басамжилсан байдлаар мушгин тайлбарлах ёсгүй.

5 дугаар зүйл

Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хувь хүн бүр үндэсний болон олон улсын түвшинд хувиараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж:

- a) Тайван замаар хуран цуглах, цуглаан хийх
- b) Төрийн бус байгууллага, эвсэл холбоо болон бүлэгт оролцох, нэгдэх болон үүсгэн бий болгох
- c) Төрийн бус байгууллага болон засгийн газар хоорондын байгууллагуудтай харилцах эрхтэй байна.

6 дугаар зүйл

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж:

a) Хүний бүхий л эрх, эрх чөлөөний тухай мэдээллийг, түүний дотор эдгээр эрх, эрх чөлөө нь дотоодын хууль тогтоомж, шүүхийн болон захиргааны тогтолцоонд хэрхэн тусгагдсан зэрэг мэдээллийг мэдэх, эрж хайх, олж авах, хүлээж авах болон хадгалах эрхтэй

b) Хүний эрхийн болон бусад холбогдох олон улсын баримт бичгүүдэд дурьдсаны дагуу хүний бүхий л эрх, эрх чөлөөний талаархи мэдлэг,

мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтлэх, бусдын үзэл бодолд нөлөөлөх, түгээн дэлгэрүүлэх эрхтэй

с) Хүний бүхий л эрх, эрх чөлөөний талаар эрх зүй болон бодит амьдралд мөрдөж баримталдаг үзэл бодолтой байх, суралцах, хэлэлцэх, эдгээр болон бусад тохиромжтой арга хэрэгслээр эдгээр үйл хэргүүдэд олон нийтийн анхаарлыг хандуулах эрхтэй.

7 дугаар зүйл

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, хүний эрхийн талаархи шинэ ойлголт, зарчмуудыг хөгжүүлэн хэлэлцэх болон тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх эрхтэй.

8 дугаар зүйл

1. Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, ямарч алагчлалгүйгээр өөрийн орны засгийн газрын үйл ажиллагаанд оролцох болон олон нийтийн үйл ажиллагааг удирдан явуулахад үр дүнтэйгээр оролцох боломжтой байх эрхтэй.

2. Мөн хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, Засгийн газрын байгууллага, агентлаг болон олон нийтийн үйл хэрэгт хамааралтай байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн биелүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахад саад болж болох тэдний ажлын аль нэг талд анхаарлыг нь хандуулах, тэдний явуулж байгаа үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн санал, шүүмжлэл танилцуулах эрхтэй.

9 дүгээр зүйл

1. Энэхүү Тунхаглалд дурдагдсанаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зэргээр хүний эрх, эрх чөлөөг ханган биелүүлэх явцад эрх нь зөрчигдсөн тохиолдолд хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж үр дүнтэй арга хэрэгслээр хамгаалуулах эрхтэй.

2. Энэ зорилгоор, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хэн боловч өөрөө болон хуулийн дагуу эрх олгогдсон төлөөллөөрөө дамжуулан гомдол гаргах, гаргасан гомдлыг нь шударга, бие даасан, эрх бүхий шүүхээр эсвэл хуулийн дагуу байгуулагдсан бусад эрх олгогдсон байгууллагуудаар хэлэлцүүлэхээс өмнө нээлттэй шүүх хурлаар хойшлуулалгүй дахин хянуулах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн дагуу цагаатгагдах, тухайн хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөнд нөхөн төлбөр авах, мөн шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр эцсийн шийдвэр болгон хэрэгжүүлүүлэх эрхтэй.

3. Мөн энэ л зорилгоор хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж:

а) Төрийн албан хаагч болон засгийн газрын байгууллагуудаас явуулж байгаа хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн бодлого, үйл ажиллагааны талаар өргөдөл, хүсэлт болон бусад тохиромжтой арга хэрэгслээр дотоодын эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага, гүйцэтгэх захиргаа болон хуулийн байгууллага, эсвэл Гишүүн орны эрх зүйн тогтолцоогоор эрх олгогдсон бусад байгууллагад гомдол гаргах эрхтэй ба гомдолд гаргасан тэдний шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр ёсоор болгох ёстой.

б) Гаргасан гомдол нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын өмнө хүлээсэн холбогдох үүрэг хариуцлага болон харилцан зөвшилцсөн үүрэгтэй нийцсэн талаар санаа бодлоо илэрхийлэхийн тулд нээлттэй шүүх хурал, шүүн хэлэлцэх ажиллагаа, шүүх хуралд оролцох эрхтэй.

в) Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар мэргэжлийн хувьд мэргэшсэн хуулийн зөвлөх болон бусад холбогдох зөвлөгөө, тусалцаагаар хангах, санал болгох эрхтэй.

4. Мөн энэ л зорилгоор, олон улсын зохих баримт бичиг, журмын дагуу хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж, нийтлэг буюу тусгай эрх бүхий олон улсын байгууллагуудтай хүний эрх, эрх чөлөөний асуудлаар холбоо харилцаатай байх, саатуулагдашгүй боломжтой байх эрхтэй.

5. Улс бүр мөрдөн шалгалтыг цаг алдалгүй шударгаар явуулах ёстой буюу үйлдэгдсэн хүний эрх, эрх чөлөөний зөрчил нь аливаа газар нутагт тухайн орны шүүн таслах эрх мэдлийн хүрээнд хамаарна гэх үндэслэлтэй учир шалтгаан байсан хэдий ч асуулт байцаалтыг явуулсан байх ёстой.

10 дугаар зүйл

Дээрээс шаардсан шийдвэр тогтоолын дагуу хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдэлд хэн ч оролцох ёсгүй. Энэхүү үйлдлийг хийхээс татгалзсаныхаа төлөө хэн ч шийтгэгдэх ёсгүй.

11 нэгдүгээр зүйл

Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, өөрийн мэргэжил албан тушаалаа хуулийн дагуу ашиглах эрхтэй. Мэргэжлийн дагуу хүний нэр

төр, хүний эрх, эрх чөлөөнд нөлөө үзүүлж чадах хэн боловч бусад хүний тэдгээр эрх, эрх чөлөөг нь хүндлэн сахих ёстой ба мэргэжлийн болон албан тушаалтны талаар холбогдох үндэсний болон олон улсын хэм хэмжээ, ёс зүйг дагаж мөрдвөл зохино.

12 дугаар зүйл

1. Хүн бүр хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихийн эсрэг үйл ажиллагаанд тайван замаар оролцох эрхтэй.

2. Улс бүр, энэхүү тунхаглалд дурьдсан эрхүүдээ хууль ёсны дагуу эдлэн, хувиараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж, заналхийлэл, хариу арга хэмжээ, хуульд заагаагүй буюу хуульд заасны дагуу алагчлах, дарамт шахалт, бусад аливаа дур зоргоороо үйлдэл зэрэг аливаа хүчирхийллийн эсрэг тэмцсэн хэн бүхнийг эрх бүхий байгууллагаар хамгаалуулах бүхий л арга хэмжээг ханган хэрэгжүүлнэ.

3. Үүнтэй холбоотойгоор, хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн болон мөн хүний эрх, эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдлэхэд нь муугаар нөлөө үзүүлэх бүлэг буюу хувь хүний үйлдсэн хүний эрхийн эсрэг тайван замаар эсэргүүцэл үзүүлэх үйл ажиллагаа, үйлдлүүдэд хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, оролцсон хүн бүр үндэсний хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэйгөөр хамгаалагдсан байх эрх олгодоно.

13 дугаар зүйл

Хүн бүр хувиараа болон эвлэлдэн нэгдэж, Энэхүү Тунхаглалын 3-р зүйлийн дагуу тайван замаар хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах тусгай зорилгоор нөөц боломжийг шаардах, хүлээн авах болон ашиглах эрхтэй.

14 дүгээр зүйл

1. Гишүүн орон нь өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд хүн бүрийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхүүдийн тухай мэдлэгээ дээшлүүлэхэд нь чиглэгдсэн хуулийн, шүүхийн болон гүйцэтгэх захиргааны болон бусад зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

2. Иймэрхүү арга хэмжээнүүд нь:

а) Хүчинтэй байгаа үндэсний хууль тогтоомж, журмууд болон холбогдох олон улсын хүний эрхийн үндсэн баримт бичгүүдийг хэвлэн нийтлэх

б) Олон улсын хүний эрхийн гэрээний байгууллагуудад Гишүүн орны тавьсан ээлжит илтгэлүүд, мөн хэлэлцсэн асуудлын товч бичиглэл болон эдгээр гэрээний байгууллагуудын албан ёсны илтгэлүүд зэрэг хүний эрхийн талбар дахь олон улсын бичиг баримтуудыг олж авах бүрэн, тэгш боломж

3. Гишүүн орон нь өөрийн шүүх эрх мэдлийн хүрээн дэх бүх нутаг дэвсгэрт омбудсман, хүний эрхийн комисс буюу үндэсний байгууллагын бусад аливаа хэлбэрийн хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний бие даасан хараат бус байгууллагуудыг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

15 дугаар зүйл

Гишүүн орон нь боловсролын бүх түвшинд хүний эрх, эрх чөлөөний тухай заахыг хөхиүлэн дэмжих, дэмжлэг үзүүлэх, мөн хуульчид, хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнууд, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон олон нийтийн ажилтнуудад хүний эрхийн сургалт явуулах хүмүүсээр хангах, тэдгээр нь хүний эрхийг заах сургалтын хөтөлбөртөө дээрх хүмүүсийн ажил үүрэгтэй холбоотой тохирох элементүүдийг багтаасан байх явдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ.

16 дугаар зүйл

Хувь хүн, төрийн бус байгууллагууд болон холбогдох байгууллагууд хүний эрхийн талбарт боловсрол олгох, сургалт, судалгааны ажил зэрэг үйл ажиллагаагаараа дамжуулан олон нийтэд хүний эрх, эрх чөлөөний талаар мэдлэг олгох, цаашилбал үндэстнүүд, арьсны өнгө болон шашны бүлэглэлүүдийн дунд ойлголцол, зөвшилцөл, энх тайван болон найрсаг харилцааг бэхжүүлэх, нийгмийн янз бүрийн давхаргад үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс санаа бодлоо хуваалцахад хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл

Хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа хүн бүр Энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ, зөвхөн холбогдох олон улсын үүрэг хариуцлагын дагуу болон гагцхүү

бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэм дэх хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуулиар тодорхойлогдсон зохих хязгаарлалтанд захирагдана.

18 дугаар зүйл

1. Хүн бүр бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангаж чадах нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээнэ.

2. Бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд ардчиллыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, ардчилсан нийгэм, байгууллага, үйл ажиллагааг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.

3. Мөн түүнчлэн бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн баримт бичгүүдэд заан тунхаглагдсан хүн бүр нийгэм, олон улсын эмх цэгцтэй байдалд байх эрхийг хөхиүлэн дэмжихэд боломжийн хирээр хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.

19 дүгээр зүйл

Энэхүү Тунхаглалын ямарч зүйлийг аль нэг улс орон, бүлэг буюу байгууллага, хувь хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг үгүйсгэхэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагаанд оролцох, тийм үйлдэл хийх эрх бололцоо олгож байгаа мэт мушгин тайлбарлаж болохгүй.

20 дугаар зүйл

Энэхүү Тунхаглалын ямарч зүйлийг Улс орны зүгээс бие хүн, байгууллага, төрийн бус байгууллагын аливаа НҮБ-ын Дүрмийн заалтуудтай харшилсан үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрсөн мэт мушгин тайлбарлаж болохгүй.